



## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### АКТ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2015. 05. 14 № 1/26

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН  
САНГИЙН ГАЗРЫН ДАРГА  
С.НАРАНЦОГТ ТАНАА

Харилцах данс хааж, орлого  
төвлөрүүлэх тухай

Үндэсний аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илрлээ. Үүнд:

- Байгаль орчин, аялал жуулчлалын яам /хуучин нэрээр/-ны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын дарга асан н.Намхай Улаанбаатар хотын банкинд 2009 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр 2611148065 дугаартай “Зайсан тохижилт” харилцах данс нээлгэн нэр бүхий 25 аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 24,700,000.00 төгрөгийн хандивын хөрөнгийг байршуулсан байна. Тухайн үед данснаас гүйлгээ хийх эрх бүхий хүмүүсийн зөвшөөрөл шийдвэрлэгдээгүйгээс уг дансыг одоо болтол ашиглаагүй байна.
- Тус банк харилцах дансны үлдэгдэлд 2009 оны 4 дүгээр сараас 2012 оны 11 дүгээр сарыг хүртэлх хугацаанд нийт 3,328,520.50 төгрөгийн хүүгийн орлого тооцож, харилцахын хүүний татвар болон данс хөтөлсний шимтгэлд 2015 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд нийт 335,312.22 төгрөгийг суутгаснаар уг харилцах дансны үлдэгдэл 27,693,208.28 төгрөг болсон байна. Харилцах дансны хуулгыг хавсаргав/

Энэ нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.11-д Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага “банкинд данс нээх зөвшөөрлийг төсвийн байгууллагад олгох” гэж заасныг зөрчиж байна.

Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д “Банкинд төрийн сангийн нэгдсэн данснаас гадуур нээсэн төсвийн байгууллагын дансанд тухайн шатны төрийн сан болон төрийн аудитын байгууллага үзлэг, хяналт хийн, энэ хуулийн 35.3-т заасан зөвшөөрөлгүйгээр нээсэн дансыг хаалгах, хөрөнгийг төрийн сангийн нэгдсэн дансанд татан төвлөрүүлнэ”, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.1-д “… төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал

гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тавинаа гэж заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын банкин дахь 2611148065 дугаартай “Зайсан тохижилт” харилцах дансыг хааж, дансны үлдэгдэл 27,693,208.28 төгрөгийг Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 900000601 тоот дансанд татан төвлөрүүлэн, биелэлтийг 2015 оны 5 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга М.Батхуяг, Төлбөр тооцооны хэлтсийн дарга Б.Отгонцэцэг нарт хариуцуулав.

### АКТЫГ

#### ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР

Г.ЮРА

УХА0122

#### ЗӨВШӨӨРСӨН:

САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮЖИЛТ,  
ТАЙЛАН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

М.БАХУЯГ

ТӨЛБӨР ТООЦООНЫ ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ОТГОНЦЭЦЭГ